



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

Барилга байгууламж акталж, нийслэлийн
өмчийн бүртгэлээс хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4.2-т заасныг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын баланст бүртгэлтэй 91,049,809.98 (ерэн нэгэн сая дөчин есөн мянга найман зуун есөн төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 65,166,149.77 (жаран таван сая нэг зуун жаран зургаан мянга нэг зуун дөчийн есөн төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад заасан 3 барилга, Чингэлтэй дүүргийн “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын баланст бүртгэлтэй 64,498,375.0 (жаран дөрвөн сая дөрвөн зуун ерэн найман мянга гурван зуун далан тав) төгрөгийн бүртгэлийн үнэтэй, 57,275,149.09 (тавин долоон сая хоёр зуун далан таван мянга нэг зуун дөчин есөн төгрөг есөн мөнгө) төгрөгийн үлдэх өртөг бүхий хавсралтад заасан барилга байгууламжийг тус тус акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100955

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн
51 дүгээр тогтоолын хавсралт

АКТАЛЖ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСАЛТ

/төргөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Байршил	Ашигласан БЖ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Акталж, данснаас хасах үндэслэл	Эзэмшигч байгууллага
1	Ус дулаан дамжуулах төв-80	Баянгол дүүрэг, 3 дугаар хороо	68	69,460,294.57	18,279,024.60	51,181,269.97	НМХГ-ын Улсын байцаагчийн 2013 оны 02-07-92/71 дүгээр дүгнэлт	"Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар" ОНӨААТҮГ
			18	19,363,680.00	5,378,800.20	13,984,879.80		
2	Конторын өргөтгөл							
3	Цехийн барилга	Баянгол дүүрэг, 7 дугаар хороо	19	2,225,835.41	2,225,835.41	0.00	ХСХГ-ын Улсын байцаагчийн 2023 оны 02-13-01/026/211 дүгээр дүгнэлт	
Дүн				91,049,809.98	25,883,660.21	65,166,149.77		
4	Салбар байр 4	Чингэлтэй дүүрэг, 23 дугаар хороо	14	61,287,975.00	7,223,225.91	54,064,749.09	НИТХ-ын 2023 оны 122 дугаар тогтоол	Чингэлтэй дүүргийн "Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв" УТҮГ
5	Хашаа		12	3,210,400.00	-	3,210,400.00		
Дүн				64,498,375.00	7,223,225.91	57,275,149.09		
Нийт дүн				155,548,184.98	33,106,886.12	122,441,298.86		